



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 5/345

Улаанбаатар хот

Б.Цэнгэлд мөнгөн тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.11.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийн гишүүн нь хүндээр өвдөж, байнгын асаргаанд байгаа тул, гаргасан хүсэлтийг нь үндэслэн Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагч Байгалмаагийн Цэнгэлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Тусламжид шаардагдах 240.000 /хоёр зуун дөчин мянган/ төгрөгийг зохих зардлаас бодож олгохыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨРӨН

000001757